



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 08 сарын 27 өдөр

Дугаар А/397

Чингис хот

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Монгол улсын Ерөнхийлөгчийн 1999 оны 71 дүгээр зарлигаар батлагдсан "Монгол улсын цол хүртээх, одон, медалиар шагнах журам"-ын 1 дүгээр хавсралтын 1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.2.20, Сангийн сайдын 2021 оны 61 дугаар тушаалаар батлагдсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2 дугаар зүйлийн 2.1.5 тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Хэнтий аймгаас шинээр төрөн гарсан гавьяатуудыг хүлээн авч хүндэтгэл үзүүлэх арга хэмжээнд зориулан 498,500 (дөрвөн зуун ерэн найман мянга таван зуу) төгрөгийн хөрөнгийг зарцуулсугай.

2.Хөрөнгө зарцуулалтын тооцоог хавсралтаар баталсугай.

3.Дээрх зардалд шаардагдах хөрөнгийг аймгийн Засаг даргын нөөц сангийн урьдчилан төлөвлөж төсөвт тусгах боломжгүй байсан нэг удаагийн шинжтэй арга хэмжээний зардлаас олгохыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д, гүйцэтгэлийг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Ганбаатар)-д даалгасугай

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231011917

Шаардагдах зардлын тооцоо

№	Зардлын төрөл	Тоо	Нэг бүрийн үнэ	Бүгд үнэ
1	Зууш	10	8500	85.000
2	1-р хоол	10	10.000	100.000
3	2-р хоол	10	13.000	130.000
4	Десерт	10	8000	80.000
5	Ус	10	2000	20.000
6	Ундаа	10	2500	25.000
7	Чихэр	2кг	15.000	30.000
8	Жимс	2кг	-	28.500
Нийт				498.500